

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2012 ОНЫ 1 ДҮГЭЭР  
УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ  
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.03.31

Улаанбаатар хот

**НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦИЙН ТАЛААР:**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан. Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж, нэгтгэлийг товч байдлаар Монголбанкинд хүрүүлж байгаа болно.

Манай улсын хэмжээнд 2012 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 194 ББСБ байгаагийн 91 нь буюу 46.9 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 91 ББСБ-ын 39 нь буюу 42.9% нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, 52 нь буюу 57.1% нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 91 ББСБ-ын 68 нь ирүүлж, 23 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 74.7 хувь байна.

/Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, танилцуулгад хавсаргав/.

Мэдээ ирүүлээгүй 23 ББСБ-ын 17 нь тус хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй бөгөөд цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг ирүүлсэн, 6 нь гадаад валютын арилжааны мэдээ болон ямар нэгэн тайлбар бичиг ирүүлээгүй болно.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 1 ББСБ-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

Мэдээ ирүүлсэн нийт 68 ББСБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг байна.

## Гадаад валютын арилжааны 2012 оны 1 дүгээр улирлын мэдээний нэгтгэл

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭ ИРҮҮЛЭХ ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭ ИРҮҮЛСЭН ББСБ-ЫН ТОО	МЭДЭЭНИЙ ИРЦ	ӨСӨЛТ, БУУРАЛТ ХУВИАР <i>/өмнөх улирлаас /</i>
1	2010 оны 1 дүгээр улирал	112	31	40.4%	0.0%
2	2010 оны 2 дугаар улирал	110	43	39.0%	-1.4%
3	2010 оны 3 дугаар улирал	109	48	44.0%	5.0%
4	2010 оны 4 дүгээр улирал	95	71	74.7%	30.7%
5	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	3.8%
6	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
7	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
8	2011 оны 4 дүгээр улирал	92	67	71.7%	17.5%
9	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%

Дээрх хүснэгтээс үзэхэд мэдээ ирүүлсэн ББСБ-уудын тоо 2010 оны 4, 2011 оны 2 дугаар улирлынхаас 8-аас 11-ээр буурсан бөгөөд мэдээний ирц 2010 оны 1,2,3 дугаар улиралд 40.4% - 44.0% байсан бол:

- 2010 оны 4 дүгээр улиралд 74.7% болж, 2011 оны 1 дүгээр улиралд 78.5% болж өмнөх улирлуудаас 30.7% - 38.1%-иар өссөн;

- 2011 оны 2 дугаар улирлын байдлаар 61.2% болж өмнөх улирлаас 17.3%-иар, 3 дугаар улирлын байдлаар 54.2% болж өмнөх улирлаас 7.0%-иар буурсан;

- 2011 оны 4 дүгээр улиралд 71.7% болж өмнөх улирлаас 17.5%-иар өсч, 2010 оны жилийн эцсийнхээс 3.0%-иар буурсан;

- 2012 оны 1 дүгээр улирлын байдлаар 74.7% болж өмнөх улирлаас 3.0%-иар өссөн байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо улирлаас улиралд буурч байгаа хэдий ч мэдээний ирц нэмэгдэх хандлагатай байна.

### **ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ТАЛААР:**

Энэхүү нэгтгэлийг ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн хийхдээ тэдгээрийн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютын болон худалдсан гадаад валют бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцсон болно.

Худалдан авсан болон худалдсан гадаад валютуудыг төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тооцож, өмнөх улиралтай харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

**Гадаад валютын арилжааны 2012 оны 1 дүгээр улирлын мэдээний нэгтгэл**

**1. Худалдаж авсан нийт гадаад валют:**

*/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/*

д/ д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ IV улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/	2012 ОНЫ I улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/
1	ТӨГРӨГ	168,060,826.6	250,598,210.7	82,537,384.1	183,318,795.4	-67,279,415.3
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	132,278.3	190,296.49	<b>58,018.19</b>	136,107.2	<b>54,189.29</b>
3	ДУНДАЖ ХАНШ	1,270.51	1,316.88	<b>46.37</b>	1,346.87	<b>29.99</b>

**Худалдсан нийт гадаад валют:**

*/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/*

д/ д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ IV улирал	2011 ОНЫ IV улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/	2012 ОНЫ I улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх улирлаас/
1	ТӨГРӨГ	163,800,118.1	258,713,488.9	<b>94,913,370.8</b>	188,755,283.7	<b>-69,958,205.2</b>
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	128,875.0	192,834.1	<b>63,959.1</b>	139,067.7	<b>-53,766.4</b>
3	ДУНДАЖ ХАНШ	1,271.0	1,341.64	<b>70.64</b>	1,357.29	<b>15.00</b>

Тайлант хугацаанд худалдаж авсан болон худалдсан нийт гадаад валютуудын ханшийг ам.долларт хөрвүүлж тэдгээрийн хоорондын зөрүүг авч үзвэл:

- Худалдан авсан нийт гадаад валютын ам.долларт хөрвүүлсэн дундаж ханш 1,346.87 төгрөг;

- Худалдсан нийт гадаад валютын ам.долларт хөрвүүлсэн дундаж ханш 1,357.29 төгрөг байгаа нь худалдсан гадаад валютын ханшийн дүн худалдан авсан валютынхаас 10.42 төгрөгөөр их гарч байна.

Энэ нь 2012 оны 3 дугаар сараас ам.долларын ханш бага багаар чангарч эхэлж буйг харуулж байгаа төдийгүй улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын /ноолуур, уул уурхай, барилга, газар тариалан гэх зэрэг/ ажил үйлчилгээ эхлэх болсонтой холбоотой гэж үзэж байна.

Тухайлбал ам.долларын албан болон зах зээлийн ханшийг 2012 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар авч үзвэл Монголбанкнаас зарласан албан ханш /1,318.80/-аас ББСБ-уудын худалдаж авсан ам.долларын ханшийн дундаж дүн 37 төгрөг 20 мөнгөөр, худалдах ханшийн дундаж дүн 41 төгрөг 20 мөнгөөр тус тус их байна.

**Гадаад валютын арилжааны 2012 оны 1 дүгээр улирлын мэдээний нэгтгэл**

Харин гадаад валютын ялангуяа ам.долларын ханш 2012 оны 01 дүгээр сараас 2012 оны 3 дугаар сарыг хүртэл буурсан ч гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийн зөрүү боломжийн түвшинд байлаа гэж үзэж байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2010, 2011 оны жилийн эцсийн байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*/ТӨГРӨГӨӨР/*

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ДҮНДАЖ ДҮН		
			2010 оны IV улирал	2011 оны IV улирал	2012 оны I улирал
1	АНУ доллар	USD	1,270.00	1,329.26	1,352.08
2	Английн фунт	GBP	1,930.96	2,054.99	2,076.05
3	Евро	EUR	1,713.68	1,744.17	1,767.03
4	БНХАУ-ын юань	CNY	188.00	202.35	210.35
5	БНСУ-ын вон	KRW	1.04	1.35	1.18
6	ОХУ-ын рубль	RUB	41.20	41.84	44.28
7	Японы иен	JPY	15.50	18.36	18.36

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг авч үзүүлвэл дараах байдалтай байна. Үүнд:

*/ТӨГРӨГӨӨР/*

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ /ӨСӨЛТ +; БУУРАЛТ -/		
			2010 оны I улирал	2011 оны IV улирал	2012 оны I улирал
1	АНУ доллар	USD	-	80.83	22.82
2	Английн фунт	GBP	-	82.72	21.06
3	Евро	EUR	-	10.68	22.86
4	БНХАУ-ын юань	CNY	-	10.75	8.00
5	БНСУ-ын вон	KRW	-	0.24	-0.17
6	ОХУ-ын рубль	RUB	-	0.24	2.44
7	Японы иен	JPY	-	2.57	-

Дээрх хүснэгтээс үзэхэд 2012 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлынхаас АНУ-ын ам.доллар 22.82 төгрөг, Английн фунт 21.06 төгрөг, Евро 22.86 төгрөг, Оросын рубль 2.44 төгрөг, Хятадын юань 8.00 төгрөгөөр тус тус өсч, БНСУ-ын вон 0.17 төгрөгөөр буурч, Японы иенийн ханш өөрчлөгдөөгүй байна. Үүнээс үндэслэн нийт гадаад валют тус бүрийн хоорондын ханшийн зөрүү харьцангуй тогтуун байсан төдийгүй огцом хэлбэлзэл гараагүй байна.